


Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн
2022 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн
04 дүгээр тогтоолын хасралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Эрүүл мэндийн удирдлага, зохион байгуулалт чиглэлээр ахлах, тэргүүлэх, зөвлөх зэрэг горилогч нь дараах тусгай шаардлагыг мөрдөнө.

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэжлийн ажлаа чадварлаг санаачилгатай гүйцэтгэж ирсэн, хамт олны хүндэтгэлийг хүлээсэн (хамт олны хурлын тэмдэглэл),
2. Сүүлийн 3 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 3-с доошгүй илтгэл 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
3. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд 3-с доошгүй өгүүллийг 1-р зохиогчоор болон хамтран зохиогчоор хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод, гадаадад мэргэжлийн сургалтад хамрагдсан, сүүлийн 5 жил тус бүр 2 багц цагийн сургалтад хамрагдсан байх (гэрчилгээ болон сургалтад хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил тус бүрээр хавсаргах),

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн ажлаа чадварлаг санаачилгатай гүйцэтгэж ирсэн, хамт олны хүндэтгэлийг хүлээсэн (хамт олны хурлын тэмдэглэл),
2. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 5-с доошгүй илтгэл 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
3. Сүүлийн 5 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд 5-с доошгүй өгүүллийг 1-р зохиогчоор болон хамтран зохиогчоор хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод, гадаадад мэргэжлийн сургалтад хамрагдсан, сүүлийн 5 жил тус бүр 2 багц цагийн сургалтад хамрагдсан байх (гэрчилгээ болон сургалтад хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил тус бүрээр хавсаргах),

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шалгуурыг хангасан байна. Үүнд:

1. Мэргэшлийн ажлаа чадварлаг санаачилгатай гүйцэтгэж ирсэн, хамт олны хүндэтгэлийг хүлээсэн (хамт олны хурлын тэмдэглэл),

2. Сүүлийн 8 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд 5-с доошгүй илтгэл, үүнээс гурав нь 1-р зохиогчоор хэлэлцүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
3. Сүүлийн 8 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцож, эрдэм шинжилгээний мэргэжлийн сэтгүүлд 3-с доошгүй өгүүлэл 1-р зохиогчоор хэвлүүлсэн байх (баримтуудыг хавсаргасан байх),
4. Дэвшин суралцах болон өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр ажиллаж дотоод, гадаадад мэргэжлийн сургалтад хамрагдсан, сүүлийн 8 жил тус бүр 2 багц цагийн сургалтад хамрагдсан байх (гэрчилгээ болон сургалтад хамрагдсаныг батлах бусад баримтыг эх хувиар нь жил тус бүрээр хавсаргах),
5. Эрүүл мэндийн удирдлага чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн бол давуу тал болно.